



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/41

Улаанбаатар хот

Хачгаар дамжих халдварт өвчнөөс
урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэг, Монгол улсын засгийн газрын 2017 оны “Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр батлах тухай” 11-р тогтоол, Эрүүл мэндийн сайдын “Заавар батлах тухай” 160 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт, Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2019 оны “Хачгаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” А/51 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Хаягаар дамжих халдварын эрсдлийг бууруулах, идэвхжлийн үеийг угтуулан тус өвчний сэжигтэй тохиолдлыг оношлох, хянах урьдчилан сэргийлэх ажлыг 2019 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд эрчимжүүлэн ажилласугай.
2. Харьяа ӨЭМТ-ийн дарга, тасгийн эрхлэгч нарт даалгах нь:
 - 2.1. Хачгаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар аж ахуйн нэгж, албан байгууллага, зорилтот бүлгийн хүн амд чиглэсэн мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлж, мэргэжил арга зүйгээр хангах.
 - 2.2. Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Заавар батлах тухай” 160 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын дагуу сэжигтэй тохиолдлын үед шаардагдах эм, урвалж, халдваргүйжүүлэх бодис, сорьц авах, тээвэрлэх, хэрэгслийн нөөцийг бүрдүүлэн, бэлэн байдлыг ханган, зааврын дагуу ажиллах
 - 2.3. Ноос ноолуур, арьс шир боловсруулах, мал аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн ажилчид болон эрсдэлт бүлгийн хүн амын судалгааг гарган ирүүлэх, эдгээр иргэдэд нийслэлийн зоонозын өвчин судлалын төв, дүүргийн холбогдох хэлтэс албадтай хамтран урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан дархлаажуулах, дархлаажуулалтын давтамжийг оновчтой сонгон, үр дүнтэй зохион байгуулж, мэдээг хугацаанд нь хүргүүлэх.
 - 2.4. ӨЭМТ болон тасаг нэгжийнхээ эмч, эмнэлгийн мэргэжилтэнд хачигт халдварын талаар сургалт зохион байгуулах.
 - 2.5. Дээрх үйл ажиллагааны явцын тайланг 2019 оны 6 дугаар сарын 19-нд, нэгдсэн тайланг 10 дугаар сарын 15-нд тус тус төвийн нийгмийн

80170 70 0358

эрүүл мэндийн алба /hey_ariunaa@yahoo.com/-нд цахим болон цаасан хэлбэрээр ирүүлэх

3. Иргэдэд чиглэсэн зөвлөмж, мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлахыг сургалт хариуцсан мэргэжилтэн /Ч.Гүнчинхорлоо/-д үүрэг болгосугай
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга /Б.Лувсанням/-д даалгасугай.

ДАРГА



Э.БОДЬЦЭЦЭГ